

Аудитын ерөнхий дүгнэлт: Хөрөнгө оруулалтын ажлын шаардлага хангаагүй ажилд санхүүжилт батлагдаж гэрээгээр ажил гүйцэтгэгч нар нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна.

**УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2017 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ,
ҮР ДҮН, ҮР АШИГ**



Зуунмод
2018 он

АГУУЛГА

<u>Аудитын тайланг бэлтгэсэн:</u>	<i>Товчилсон үгийн тайлбар</i> 4
Төв аймаг дахь Төрийн аудитын газар	<i>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт</i> 6
Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал	БҮЛЭГ А. Хөрөнгө оруулалтын ажил нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлтэй уялдсан боловч хөрөнгө оруулалтын ажлын шаардлага хангаагүй ажлуудад санхүүжилт батлагджээ. 8
Аудитын менежер О.Амаржаргал Ахлах Аудитор Л.Жаргалсайхан Аудитор Ч.Загдсүрэн	<i>А.1 2017 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлууд нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдсан байна.</i> 9
2018 оны 06 дугаар сарын 10	<i>А.2. 2017 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр жагсаалтаар батлагдсан хөрөнгө оруулалтын ажлын 25 хувь нь зураг, төсөвтэй, 75 хувь нь зураг, төсөвгүй, хөрөнгө оруулалтын ажлын шаардлага хангаагүй байна.</i> 10
<i>Уг тайланг АГ-ын Веб сайтаас үзнэ үү.</i> www.tuv-audit.mn	<i>А.3 Аймгийн Орон нутгийн өмчийн газраас ХАА-ны төлөвлөгөөг ТЕЗ-аар батлуулж ажилласан байна.</i> 11
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70273463 дугаарын утас, 70272287 дугаарын факсаар харилцана уу.	БҮЛЭГ Б. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр гэрээгээр ажил гүйцэтгэсэн компаниуд нь гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй, тэдэнтэй тооцох хариуцлага хангалтгүй байна. 12
	<i>Б.1 Зураг, төсөвгүй ажилд санхүүжилт батлагдсанаас худалдан авах ажиллагааг төсөвт өртгөөр бус батлагдсан санхүүжилтээр зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулжээ.</i> 13
	<i>Б.2 2017 онд улс, орон нутгийн төсвөөс хэрэгжсэн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээний 42 хувь нь гэрээний хугацаанд хэрэгжээгүй, ашиглалтад орох хугацаандаа ороогүй байна.</i> 14
ХАЯГ: Төв аймгийн Төрийн байгууллагын ордон	<i>Б.3 Захиалагчаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчтэй тооцох хариуцлагыг бүрэн тооцоогүй, зарим гэрээний хугацаа хэтэрсэн хоногт тооцох алдангийн хэмжээ тодорхойгүй, чанарын баталгаат хугацааны барьцаа хөрөнгийг бүрэн тооцож аваагүй байна.</i> 17

Б.4 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 5 ажилд 73.6 сая төгрөгийн нэмэлт ажлын гэрээ байгуулсан боловч 8.8 сая төгрөгийн магадалшгүй ажлын зардлыг актаар санхүүжүүлжээ.

*Дүгнэлт
Зөвлөмж*

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их хурал
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ССАЖЯ	Соёл спорт аялал жуулчлалын яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БХБЯ	Барилга хот байгуулалтын яам
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЭХЯ	Эрчим хүчний яам
ТББ	Тендерийн баримт бичиг
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТООЗ	Тендерт оролцогчдод өгөх зөвлөмж

ТАХ	Төсөл арга хэмжээ
ГЕН	Гэрээний ерөнхий нөхцөл
ДЭХГ	Дулааны эрчим хүчний газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийх үндэслэл:

Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Төрийн аудитын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт:

“Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” сэдэвт гүйцэтгэлийн аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Энэ зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийсэн. Үүнд:

-Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх,

-Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх,

-Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөж, үр нөлөөг бодитой тооцож, үнэлсэн эсэх,

Аудитын хамрах хүрээ:

Аудитад улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 997.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ажил, аймгийн орон нутгийн төсвийн нийт 3 эх үүсвэрээс санхүүжүүлсэн 4172.2 сая төгрөгийн 67 төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт болон эдгээр төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгчдийн үйл ажиллагааг хамруулсан.

Үндсэн мэдээлэл: “Монгол улсын 2017 оны төсвийн тухай” хуулиар “Монгол улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт” батлагдсанаас Төв аймагт 3 сайдын багцаас төсвийн тухай хуулиар 997.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 хөрөнгө оруулалтад 917.1 сая төгрөг батлагдсан бөгөөд Эрчим хүчний сайдын багцаас 2017-2018 он дамжин хэрэгжих 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ажилд 120.0 сая төгрөг батлагджээ. Дээрх ажлуудад 933.5 сая төгрөгийн гэрээ байгуулагдаж, 856.4 сая төгрөг буюу батлагдсан санхүүжилт гэрээний дагуу бүрэн олгогдсон байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор “2017 оны төсөв”-ийг 2016 оны 12 сарын 2-ны өдөр, төсвийн шилжих үлдэгдлийн жагсаалтыг 2017 оны 2 сарын 20-ны өдөр, “аймгийн 2017 оны төсөв”-ийг 2017 оны 5 сарын 30, 2017 оны 12 сарын 04-ны өдөр буюу 2 удаа тодотгон баталжээ. Үүнд:

-аймгийн төсвийн шилжих үлдэгдлээс 3039.9 сая төгрөгийн 35 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ батлагдаж он дамжин хэрэгжсэн 4 хөрөнгө оруулалтын ажилд 472.6 сая төгрөгийн, шинээр хэрэгжсэн 26 ажилд 1 636.2 сая төгрөгийн, бусад зардал буюу аймаг хөгжүүлэх сан, ГХУС гэх мэт 6 төрлийн зардалд 876.2 сая төгрөгийн, нийт 36 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд 2 985.0 сая төгрөг,

-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 705.2 сая төгрөгийн 18 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд 19 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд 612.2 сая төгрөг

-Орон нутгийн замын сангаас 427.1 сая төгрөгийн 14 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан 14 хөрөнгө оруулалтын ажилд 411.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Эрсдэлийн үнэлгээ: Төлөвлөлтийн үе шатны ажлын явцад цуглуулж судалсан баримт, материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн хийх аудитын эрсдэлийн ерөнхий үнэлгээг “Дунд” гэж үзлээ.

Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах бөгөөд шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа авах, байгууллагын худалдан авалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон бусад шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийж АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан холбогдох албан тушаалтантай ярилцлага хийж асуулга лавлагаа авсан.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашигласан.

- Барилгын тухай хууль
- Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Дээрх хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарсан УИХ, ЗГ-ын тогтоол, бусад эрхийн актууд
- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”
- Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

Аудит хийх бүрэлдэхүүн: Аудитыг аймгийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал удирдан, ахлах аудитор Л.Жаргалсайхан, аудитор Ч.Загдсүрэн нар хийж гүйцэтгэв.

Аудитын хугацаа:

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 12-ноос эхэлж, 6 дугаар сарын 08-ны өдрийн дотор хүргүүлээ.

Бүлэг А *Хөрөнгө оруулалтын ажил нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлтэй уялдсан боловч хөрөнгө оруулалтын ажлын шаардлага хангаагүй ажлуудад санхүүжилт батлагджээ.*

А.1 2017 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлууд нь “2016-2020 онд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” болон “аймгийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлтэй” уялдсан байна.

2017 онд улс, орон нутгийн төсвөөс 5089.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан 75 төсөл хөтөлбөр, арга хэмжээ нь “2016-2020 онд Төв аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” болон “аймгийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлтэй” уялдсан байна.

	Санхүүжилтийн эх үүсвэр	Батлагдсан ажлын			Батлагдсан санхүүжилт
		тоо	төсөвт өртөг	Төсвийн тухай хуулиархи төсөвт өртөг	
А	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	9	1086.9	997.1	917.1
	Үүнээс:				
1	Эрүүл мэндийн сайдын	3	254.3	209.0	209.0
2	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын	5	632.6	588.1	588.1
3	Эрчим хүчний сайдын	1	200.0	200.0	120.0
Б	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	66	4090.5	444.8	4172.2
	Үүнээс:				
1	Орон нутгийн төсвийн шилжих үлдэгдэл	34	2946.3		3039.9
	үүнээс урд оны үлдэгдэл санхүүжилт	5			515.4
2	Орон нутгийн замын сангаас	14	444.2	444.8	427.1
	үүнээс урд оны үлдэгдэл санхүүжилт	1			12.4
3	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын зардлаас	18	700.0		705.2
	БҮГД	75	5177.4	1441.9	5089.3
	Үүнээс:				
	урд оны үлдэгдэл санхүүжилт	6			527.8
	шинээр хэрэгжих	69	5177.4	1441.9	4561.5

“Монгол улсын 2017 оны төсвийн тухай” хуулиар “Монгол улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт” батлагдсанаас 3 сайдын багцаас 1086.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, төсвийн тухай хуулиар 997.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 хөрөнгө оруулалтад 917.1 сая төгрөг батлагдсанаас 200.0 сая төгрөгийн өртөгтэй он дамжин хэрэгжих 1 ажилд 120.0 сая төгрөг батлагдаж, үлдсэн 8 ажлын санхүүжилт төсөвт өртгөөсөө 89.8 сая төгрөгөөр дутуу батлагдсан байна. Үүнд:

1.Эрүүл мэндийн салбарын их засварын зардлаас 254.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 хөрөнгө оруулалтын ажилд 209.0 сая төгрөг,

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан соёл спортын сайдын барилга, байгууламжийн өргөтгөл, их засварын зардлаас 632.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 их засварын ажилд 588.1 сая төгрөг

3.Эрчим хүчний сайдын хөрөнгө оруулалтын зардлаас 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2017-2018 он дамжин хэрэгжих 1 ажилд 120.0 сая төгрөгийн санхүүжилт батлагджээ.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 3 дугаар хуралдааны “аймгийн 2017 оны төсөв батлах тухай” 3 тоот тогтоолоор аймгийн замын сан болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 14 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд 873.4 сая төгрөг, 2017 оны 02 сарын 20-ны өдрийн 9 дүгээр хуралдааны 5 тоот тогтоолоор аймгийн орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлээс 18 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд 2260.5 сая төгрөгийн санхүүжилт баталсан бөгөөд нийт 3133.9 сая төгрөгийн 32 ажлыг 2017 онд орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор анх батлагдсан орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний төлөвлөгөөнд 5, 12 саруудад 2 удаа тодотгол хийжээ.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдөр хуралдсан 7 дугаар хуралдааны 01 тоот тогтоолоор нийт 4172.2 сая төгрөгийн 66 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний санхүүжилтийг тодотгон баталснаас 527.8 сая төгрөг нь урд оны 6 ажлын үлдэгдэл санхүүжилт байна.

2017 онд шинээр нийт 66 төсөл хөтөлбөр, арга хэмжээнд 4090.5 сая төгрөгийн санхүүжилт баталжээ. Үүнд:

1.аймгийн төсвийн шилжих үлдэгдлээс 29 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд 2524.5 сая төгрөг,

2.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 18 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд 705.2 сая төгрөгийн

3.аймгийн орон нутгийн замын сангаас 13 хөрөнгө оруулалтын ажилд 414.7 сая төгрөг байна.

Аймгийн ИТХТ-ийн 2016 оны 10 сарын 13-ны өдрийн “Эрэмбэлсэн дараалал батлах тухай” 41 тоот тогтоолоор сумдын нийгмийн салбарын барилга байгууламж шинээр барих, өргөтгөл, засвар хийх эрэмбэ дарааллаар:

1.сургуулийн хичээлийн байр, гал тогоо,

2.сургуулийн дотуур байрны барилгын шинээр болон их засвар,

3.цэцэрлэгийн барилга шинээр барих, өргөтгөл, их засвар,

4.сумдын Засаг даргын тамгын газрын конторын барилга,

5.соёлын төвийн барилга, их засварын ажлуудын эрэмбэ дарааллыг, аймгийн Засаг даргын 2016 оны 11 сарын 29-ний өдрийн А/662 тоот “Автомашинны парк шинэчлэх эрэмбэ дараалал тогтоох тухай” захирамжаар сумдын ЗДТГ, эрүүл мэндийн төвүүдийн автомашины парк шинэчлэх эрэмбэ дарааллыг тогтоосон байна. Дээрх шийдвэрүүдээр улсын төсөв, гадаад дотоодын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэхдээ энэхүү дарааллыг мөрдлөг болгохоор заасан байна.

2017 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийгмийн салбарт хэрэгжүүлэхээр баталсан 13 хөрөнгө оруулалтын ажлын 6 ажилд эрэмбэлэгдсэн дараалал зөрчиж санхүүжилт батлагдсаны 5 нь улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих ажлууд байна. Үүнд:

- Цээл сумын эрүүл мэндийн төвийн барилгын ажил 13-т /улсын төсөв/
- Батсүмбэр сумын бага сургууль, спорт заалны өргөтгөлийн засварын ажил 11-т /улсын төсөв/,
- Баян сумын сургуулийн дотуур байрны барилгын засварын ажил 6-д /улсын төсөв/,
- Эрдэнэсант сумын Залуучуудын соёл, спортын төвийн барилгын засвар 7-д /улсын төсөв/,
- Жаргалант сумын цэцэрлэгийн барилгын засварын ажил 5-д /улсын төсөв/,
- Цэцэрлэгийн барилгын их засварын оролцоо /Борнуур/ 32-т /орон нутгийн төсөв/ эрэмбэлэгдсэн байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар эрэмбэлэгдсэн сумын ЗДТГ-ын автомашины парк шинэчлэлийн жагсаалтаар 5 сумын автомашинд дарааллын дагуу санхүүжилтийг баталсан байна.

2017 онд улс, орон нутгийн төсвөөс 4561.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан 69 төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлуудыг ангилбал:

- барилга байгууламжийн их засвар болон шинээр хийгдэх бүтээн байгуулалтын 38 ажилд 2694.8 сая төгрөг,
- техник, тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах 9 ажилд 575.3 сая төгрөг,
- бусад шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын 6 ажилд 251.5 сая төгрөг,
- зураг, төсвийн 3 ажилд 58.0 сая төгрөг,
- бусад 2 ажилд 16.0 сая төгрөг,
- бусад үйл ажиллагаа болон арга хэмжээний 11 зардалд 965.9 сая төгрөг баталжээ.

№	Төсөл, арга хэмжээний төрөл	Ажлын тоо	төсөвт өртөг	Батлагдсан санхүүжилт
	А.Барилга байгууламжийн ажил	38	3268.9	2694.8
1	Шинэ баригдах барилга, байгууламж	7	617.3	618
2	Их засвар	15	1781.4	1354.1
3	Шинээр хийгдэх дэд бүтэц	15	815.2	667.7
	-цахилгаан шугам сүлжээ	1	200.0	120.0
	-Дулаан хангамж, цэвэр бохир усны шугам	2	206.1	168.1
	-Авто зам засвар шинэчлэл	12	409.1	379.6
4	Барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгө худалдан авалт	1	55.0	55.0
	Б.Техник, тоног төхөөрөмж, бараа материал худалдан авалт	9	575.3	575.3
1	Автомашин худалдан авалт	5	427.1	427.1
2	Бусад хөрөнгө худалдан авалт	4	148.2	148.2
	В.Бусад шинээр хийгдэх хөрөнгө оруулалтын ажил	6	293.3	251.5
	Г.Зураг, төсөв	3	58.0	58.0
	Д.Бусад ажил	2	16.0	16.0
	Д.Бусад арга хэмжээний зардал	11	965.8	965.9
	БҮГД	69	5177.3	4561.5

А.2 2017 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр жагсаалтаар батлагдсан хөрөнгө оруулалтын ажлын 28 хувь нь зураг, төсөвтэй, 72 хувь нь зураг, төсөвгүй, хөрөнгө оруулалтын ажлын шаардлага хангаагүй байна.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр баталсан 4561.9 сая төгрөгийн санхүүжилттэй 69 төсөл хөтөлбөр, арга хэмжээ нь нэр, хэрэгжих хугацаа, байршлаар батлагджээ. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас батлагдсан 254.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөв цөөрмийн ажил нь Зуунмод суманд хөв цөөрөм, цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил болж өөрчлөгдсөн боловч тодотголоор хөрөнгө оруулалтын ажлын батлагдсан нэрийг өөрчлөлгүй хэвээр баталсан байна.

Аймгийн төсвийн шилжих үлдэгдлээс 2017 онд санхүүжүүлэх, хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтад хөрөнгө оруулалтын бус шинж чанартай 876.2 сая төгрөгийн 6 ажил, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 105.6 сая төгрөгийн 7 ажил батлагджээ.

№	Төсөл, арга хэмжээний төрөл	Ажлын тоо	төсөвт өртөг	Батлагдсан санхүүжилт
	Шинээр хийгдэх төсөл, арга хэмжээ бүгд	69	5177.3	4561.5
1	Үүнээс: -Хөрөнгө оруулалтын	56	4195.5	3579.7
2	-Үйл ажиллагаа, арга хэмжээний	13	981.8	981.8

Жагсаалтаар батлагдсан төсөл арга хэмжээнээс зураг, төсвийн дагуу хийгдэх 3249.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 37 хөрөнгө оруулалтын ажлаас 1229.7 сая

төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ажлын зураг, төсөв 2016 онд хийгдэж, үлдсэн 2020.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 27 ажлын зураг, төсөв 2017 онд хийгдсэн байна. Үүнд:

-Улсын төсвөөс хэрэгжихээр батлагдсан 1077.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ажлаас 792.0 сая төгрөгийн 6 ажлын,

-Орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлээс батлагдсан 1379.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 ажлаас 704.3 сая төгрөгийн өртөгтэй 12 ажлын,

-Орон нутгийн замын сангийн 347.4 сая төгрөгийн өртөгтэй 9 ажлаас 79.0 сая төгрөгийн өртөгтэй 4 ажлын,

-Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 444.8 сая төгрөгийн өртөгтэй 5 ажлын зураг, төсөв бүгд 2017 онд хийгдсэн байна.

№	Хөрөнгө оруулалтын ажлын зураг, төсөв хийгдсэн хугацаа	Ажлын тоо	төсөвт өртөг	Батлагдсан санхүүжилт
A	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	8	1077.9	908.1
	2016 онд зураг төсөв хийгдсэн	2	285.9	260
	2017 онд зураг төсөв хийгдсэн	6	792.0	648.1
Б	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	29	2171.9	1734.6
	Орон нутаг 2016 онд	8	943.8	548.2
	Орон нутаг 2017 онд	21	1228.1	1186.4
1	Орон нутгийн төсвийн шилжих үлдэгдэл	15	1379.7	967.1
	2016 онд зураг төсөв хийгдсэн	3	675.4	310.3
	2017 онд зураг төсөв хийгдсэн	12	704.3	656.8
2	Орон нутгийн замын сан	9	347.4	317.5
	2016 онд зураг төсөв хийгдсэн	5	268.4	237.9
	2017 онд зураг төсөв хийгдсэн	4	79.0	79.6
3	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал	5	444.8	450
	2016 онд зураг төсөв хийгдсэн			
	2017 онд зураг төсөв хийгдсэн	5	444.8	450.0
	Улс, орон нутаг бүгд	37	3249.8	2642.7
	Үүнээс:2016 онд	10	1229.7	808.2
	2017 онд	27	2020.1	1834.5

Зураг, төсөвгүй ажилд санхүүжилт баталснаас зарим ажлын төсөвт өртөг, санхүүжилтийн хооронд зөрүү гарчээ. Жишээлбэл: Цээл сумын эрүүл мэндийн төвийн барилгын ажлын төсөвт өртөг 135.0 сая төгрөг, батлагдсан санхүүжилт 120.0 сая төгрөг, Баянцагаан сумын ЭМТ-ийн барилгын дотор халаалт, туслах байрны барилгын засварын ажлын төсөвт өртөг нь 109.6 сая төгрөг, батлагдсан санхүүжилт 80.0 сая төгрөг, нийтийн дуудлага худалдаагаар зарагдсан газрын шинэ суурьшлын бүсийн гэр хорооллыг эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбох ажлын төсөвт өртөг 195.3 сая төгрөг батлагдсан санхүүжилт 160.0 сая төгрөг, Зуунмод сумын цэцэрлэгт хүрээлэн, хөв цөөрмийн ажлын төсөвт өртөг 254.0 сая төгрөг, санхүүжилт нь 265.0 сая төгрөг, Соёл амралтын хүрээлэнд усан оргилуур байгуулах ажлын төсөвт өртөг 78.4 сая төгрөг, санхүүжилт 80.0 сая төгрөг гэх мэтээр санхүүжилт нь төсөвт өртөгөөсөө нэмэгдэх буюу хасагдаж батлагджээ.

Эдгээр ажлуудаас улсын төсвөөс санхүүжих 135.7 сая төгрөгийн өртөгтэй Цээл сумын эрүүл мэндийн төвийн барилгын ажил, орон нутгийн төсвөөс санхүүжих

224.3 сая төгрөгийн өртөгтэй Сүмбэр сумын эрүүл мэндийн төвийн барилгын их засварын ажлуудад магадлалын ерөнхий дүгнэлт гаргаж баталгаажуулсан, үлдсэн 2889.8 сая төгрөгийн өртөгтэй 35 ажлын зураг, төсөв нь экспертизийн дүгнэлтээр баталгаажуулаагүй байна.

ДОЗТ БГБХН нь Батсүмбэр сумын бага сургууль, спорт заалны барилгын засвар, Эдшил ХХК нь Жаргалант сумын цэцэрлэгийн барилгын засварын ажлын зураг, төсвийг хийх гэрээ байгуулж, гэрээнд экспертизийн дүгнэлт гаргуулахаар тусгасан боловч уг ажил хийгдээгүй байна.

2017 онд шинээр газрын зөвшөөрөл гаргаж хийгдэх Сэргэлэн сумын цагдаагийн пост, Зуунмод сумын хөв цөөрөм, цэцэрлэгт хүрээлэн барих 2 ажлын газрын зөвшөөрөл олгогдсон, Зуунмод суманд худаг гаргах, усан сангуудыг цахимжуулах ажлын хүрээнд шинээр баригдсан 2 худгийн барилгын кадастарын зураг хийгдсэн, газрын зөвшөөрөл олгогдоогүй байна.



БОХНСАзардлаас хэрэгжсэн хөв цөөрөм, цэцэрлэгт хүрээлэн /Ар булаг ХХК-238.9 сая төгрөг/



Цахим худаг /Эко Гео ХХК-2 худаг 80.0 сая төгрөг/

Эдгээр зөрчлүүд нь “Төсвийн тухай хууль”-ийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, “Барилгын тухай” хуулийн “Барилгын тухай” хуулийн 24.1-д “Барилга, байгууламжийн төсвийн тооцоо хийх, төлөвлөх, батлах, хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 24.1.1-д “батлагдсан зураг, төсөлд үндэслэсэн байх”, МУ-ын сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 3.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч аймаг, нийслэл төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, тухайн санхүүгийн жилийн төсөлд тусгахдаа дараах зарчмыг баримтална. Үүнд: Шинээр баригдах барилга, байгууламжийн ТЭЗҮ батлагдсан зураг төсөв, үр ашгийн тооцоо, нийгмийн шинж чанартай барилга байгууламжийн хувьд түүнийг барих зайлшгүй хэрэгцээ шаардлага, судалгаа, тооцоо, батлагдсан зураг төсвийг үндэслэх, 3.2-т “тухайн санхүүгийн жилд эхлүүлэхээр төлөвлөж буй барилга байгууламж нь 3.1-т заасан зарчмыг баримталсан байхын зэрэгцээ инженер хайгуулын судалгааг хийж, дүгнэлт гаргасан, зураг төслийг экспертизээр батлуулсан, барилга барих газар

болон инженерийн шугам, сүлжээний асуудлыг бүрэн шийдсэн, үр ашигтай ТЭЗҮ, тооцоогоор нотлогдсон зэрэг барилгын ажлыг эхлүүлэх нөхцөлийг хангасан, урсгал зардлын урьдчилсан тооцоо хийгдсэн байна”, 3.4-т “Төсвийн хөрөнгөөр хийх их засварын ажлыг төлөвлөхдөө тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох материалыг үндэслэнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

А.3 Аймгийн Орон нутгийн өмчийн газраас ХАА-ны төлөвлөгөөг ТЭЗ-аар батлуулж ажилласан байна.

“Монгол улсын 2017 оны төсвийн тухай” хуулиар санхүүжилт нь батлагдсан 997.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 хөрөнгө оруулалтын ажлаас 797.1 сая төгрөгийн 8 ажил тухайн ондоо, 2017-2018 он дамжин хэрэгжих 200.0 сая төгрөгийн өртөгтэй 1 ажилд 120.0 сая төгрөг, орон нутгийн төсвийн 3 эх үүсвэрээс шинээр хэрэгжих 3644.4 сая төгрөгийн 60 төсөл хөтөлбөр, арга хэмжээг 2017 онд хэрэгжүүлэхээр баталжээ.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих 9 хөрөнгө оруулалтын ажил нь аймгийн Засаг дарга буюу Төсвийн ерөнхийлөн захирагчид 1-5 саруудад тухайн салбарын сайдын албан тоотоор эрх шилжиж ирсэн байна.

Аймгийн “Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны ХАА-ны төлөвлөгөө”-г “Аймгийн төсөв” батлагдсаны дараа буюу 2016 оны 12 сарын 15-ны өдөр Орон нутгийн өмчийн газраас батлуулсан байна. Мөн аймгийн Засаг даргын 2017 оны 03 сарын 14-ны А/155 тоот захирамж, 2017 оны 06 сарын 07-ны А/319 тоот захирамжуудаар улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлын ХАА-ны төлөвлөгөө батлагджээ.

Бүлэг Б

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр гэрээгээр ажил гүйцэтгэсэн компаниуд нь гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй, тэдэнтэй тооцох хариуцлага хангалтгүй байна.

Б.1 Зураг, төсөвгүй ажилд санхүүжилт батлагдснаас зарим ажлын худалдан авах ажиллагааг төсөвт өртгөөр бус батлагдсан санхүүжилтээр зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулжээ.

2017 онд хэрэгжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалтын шинж чанартай 4195.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 56 ажил, БОХНСАХЗ-аас батлагдсан ус болон тарвага тооллогын 16.0 сая төгрөгийн, нийт 4211.6 сая төгрөгийн өртөгтэй 58 ажлын гүйцэтгэгчийг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу шалгаруулжээ. Үүнд:

-Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих 1086.9 сая төгрөгийн өртөгтэй 9 ажлын гүйцэтгэгчийг нээлттэй 7, харьцуулалтаар 1, шууд худалдан авалтаар 1 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаас нээлттэй 5, харьцуулалтаар 2, шууд худалдан авалтаар 2 ажлын,

-Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 3157.5 сая төгрөгийн өртөгтэй 49 ажлын гүйцэтгэгчийг нээлттэй 9, харьцуулалтаар 32, шууд худалдан авалтаар 8 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаас нээлттэй 7, харьцуулалтаар 27, шууд худалдан авалтаар 15 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

№	Худалдан авалт эх үүсвэрээр	төсөвт өртөг	ХАА-ны төлөвлөгөөнд тусгасан төсөвт өртөг	Батлагдсан санхүүжилт	ХАА зохион байгуулагдах ажлын тоо	Төсөвт өртгөөр			ХАА		
						НТШ	ХА	шууд	НТШ	ХА	шууд
1	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	1086.9	997.1	917.1	9	7	1	1	5	2	2
	Орон нутгийн төсвийн шилжих хөрөнгө оруулалт	2070.1	2000.7	1648.3	23	6	17	0	4	15	4
	Орон нутгийн замын сан	444.2	444.8	414.7	13	2	8	3	2	6	5
	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын зардал	610.4	615.6	615.6	13	1	7	5	1	6	6
2	Орон нутаг бүгд	3124.7	3061.1	2678.6	49	9	32	8	7	27	15
4	2017 оны нийт хөрөнгө оруулалт	4211.6	4058.2	3595.7	58	16	33	9	12	29	17

Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар нийт 2737.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаас 12 ажлыг нээлттэй, 2 ажлыг харьцуулалтаар, 2 ажлыг шууд худалдан авалт хийсэн байна. Үүнд:

-Улсын төсвөөс хэрэгжсэн 109.6 сая төгрөгийн өртөгтэй Баянцагаан сумын ЭМТ-ийн барилгын дотор халаалт, туслах байрны барилгын засвар ажлыг 80.0 сая төгрөгөөр, 159.6 сая төгрөгийн санхүүжилттэй 5 сумын ЗДТГ-ын албан хэрэгцээний

суудлын автомашины парк шинэчлэл /Цээл, Баянжаргалан, Эрдэнэсант, Аргалант, Борнуур/-ийг ТБОНӨХБАУХАТ хуулийн 8 дугаар 8.6 дахь заалтын дагуу төсөвт өртгийг хувааж харьцуулалтаар,

-200.0 сая төгрөгийн өртөгтэй Батсүмбэр сумын Сөгнөгөр багийн цахилгаан хангамжийн шинэчлэл АТП-8190-ийн 0.4-н агаарын шугамын угсралтын ажил Эрчим хүчний сайдаас 9 сард эрх нь шилжиж, 10 сард үнэлгээний хороо байгуулагдсанаас цаг хугацааны хувьд худалдан авах ажиллагаа явуулах боломжгүй болж ТБОНӨХБАУХАТухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалтыг үндэслэн, 180.0 сая төгрөгөөр аймгийн Засаг даргын авто машинийг шууд гэрээ байгуулжээ.

Тендер шалгаруулалтын онцгой журмын харьцуулалтын аргаар нийт 1405.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 33 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаас харьцуулалтаар 27, шууд худалдан авалтаар 6 ажлын гэрээ байгуулагджээ. Үүнд:

-Аймгийн ЗДТГ-ын 12.0 сая төгрөгийн өртөгтэй зарим өрөөний засварын ажил, 55.0 сая төгрөгийн өртөгтэй Угтаалцайдам сумын цэцэрлэгийн барилгын өргөтгөл, ажил, 20 сумын булаг шанд, рашааны эхийг тохижуулж, хамгаалах 30.0 сая төгрөгийн ажил, 45.0 сая төгрөгийн өртөгтэй Зуунмод хот доторх авто замын зам арчлалт зэрэг ажлууд байна.

Шууд гэрээ байгуулах 68.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгожээ.

Худалдан авах ажиллагааг төсөвт өртгөөр нь харуулбал:

№	Төсөл, арга хэмжээний нэр	Ажлын тоо	төсөвт өртөг	ХАА-ны төлөвлөгөөнд тусгасан төсөвт өртөг	Батлагдсан санхүүжилт	ХАА		
						НТШ	ХА	шууд
	1.Улсын төсвийн хөрөнгө оруулалт	9	1086.9	997.1	917.1	5	2	2
1	Нээлттэй тендер	7	1036.5	953.1	873.1	5	1	1
2	Харьцуулалт	1	41.4	35	35	0	1	0
3	Шууд худалдан авалт	1	9	9	9	0	0	1
	2.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	49	3124.7	3061.2	2678.6	7	27	15
1	Нээлттэй тендер	9	1701.0	1661.4	1281.4	7	1	1
2	Харьцуулалт	32	1364.1	1340.2	1337.6	0	26	6
3	Шууд худалдан авалт	8	59.6	59.6	59.6	0	0	8
	Улс, орон нутаг бүгд	58	4211.6	4058.3	3595.7	12	29	17
1	Нээлттэй тендер	16	2737.5	2614.5	2154.5	12	2	2
2	Харьцуулалт	33	1405.5	1375.2	1372.6	0	27	6
3	Шууд худалдан авалт	9	68.6	68.6	68.6	0	0	9

Аймгийн Засаг даргын нийт 29 удаагийн захирамжаар 2017 онд хийгдэх 10.0 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй 49 хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулжээ.

Аудит хийх явцад дараах зөрчлүүд илэрлээ. Жишээлбэл:

-Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан 49 хөрөнгө оруулалтын ажлын 22-ынх нь гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 5 гишүүнтэй үнэлгээний хорооны бүрэлдэхүүний 50-аас дээш хувь буюу 3-4 гишүүн нь аймгийн Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагааны ажилтнууд байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47.4-т "Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын 2-оос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн ИТХ-аас томилсон иргэн, ЗДТГ-ын ажилтныг оролцуулна",

-Зураг, төсөвгүй ажилд санхүүжилт батлагдсанаар зарим ажлын худалдан авах ажиллагааг тухайн ажлын төсөвт өртгөөр бус батлагдсан санхүүжилтээр зохион байгуулжээ. Улсын төсвөөс хэрэгжсэн 1086.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ажилд 917.1 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж, 6 ажлын ХАА-г тухайн ажлын төсөвт өртгөөр бус, батлагдсан санхүүжилтээр зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулжээ. Жишээлбэл: Цээл сумын эрүүл мэндийн төвийн барилгын ажлын төсөвт өртөг 135.0 сая төгрөг, батлагдсан санхүүжилт 120.0 сая төгрөг, Баянцагаан сумын ЭМТ-ийн барилгын дотор халаалт, туслах байрны барилгын засварын ажлын төсөвт өртөг нь 109.6 сая төгрөг, батлагдсан санхүүжилт 80.0 сая төгрөг гэх мэт 6 ажлын төсөвт өртгийг бууруулсан, орон нутгийн төсвөөс хэрэгжсэн Зуунмод сумын хөв цөөрөм, цэцэрлэгт хүрээлэнгийн төсөвт өртөг 254.0 сая төгрөг, батлагдсан санхүүжилт 265.0 сая төгрөг бөгөөд ХАА-г 265.0 сая төгрөгөөр зохион байгуулжээ. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8.2-т "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ", 8.4-т "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", 28.3-д "Шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлэх үндсэн шалгуур нь үнэ байна",

-Баянцагаан сумын ЭМТ-ийн барилгын дотор халаалт, туслах байрны барилгын засварын ажлын төсөвт өртөг нь 109.6 сая төгрөг бөгөөд 80.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаар нээлттэй тендер шалгаруулалтаар зохион байгуулагдах ХАА-г батлагдсан санхүүжилтээр харьцуулалтын аргаар зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8.2-т "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ", 8.4-т "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", 8.5"-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, тендер шалгаруулалт явуулахыг хориглоно",

-168.9 сая төгрөгийн өртөгтэй Баруун Зуунмод багийн гэр хорооллын гадна дулаан хангамж, цэвэр бохир усны шугам угсралтын ажлын тендер 9 компани оролцсоноос үнийн саналаар 8-д орсон Төв Чандмань ДЭХГ шалгарсан байна. Тус компани 13.3 сая төгрөгийн нэмэлт ажлыг үнийн саналдаа багтаан гүйцэтгэхээр төсвөө ирүүлсэн байна. Үнэлгээний хорооны гишүүн төсөвчин С.Эрдэнэчимэг нэмэлт ажлын төсвийг хянаж үзээд 23.5 сая төгрөгийн ажил байна гээд Төв Чандмань ДЭХГ-ын ирүүлсэн үнийн саналаас хасаж тооцсон, мөн дотоодын давуу эрх тооцуулах хүсэлт ирүүлээгүй байхад тооцож шалгаруулж, ирүүлсэн үнийн саналаар гэрээ байгуулах эрх олгосон байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 7.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй хариуцлагатай байх зарчмыг баримтална", Сангийн сайдын 2016 оны

415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.20-д "ТБОНӨХБАҮХАТ хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсвөөс санхүүжүүлэхийг хориглоно",

-Тус ажлын тендер шалгаруулалт сангийн яаманд тендерт оролцогчоос гомдол гарсан тул 2 удаа зарлагдаж “шаардлага хангасан оролцогч байхгүй тул шууд гэрээ байгуулах зөвлөмжийг үнэлгээний хорооноос захиалагч ГХБХБГ-т хүргүүлжээ. Захиалагч нь тендер шалгаруулалтаар шаардлага хангахгүй гэсэн дүгнэлт гарсан Төв Чандмань ДЭХГ-тай шууд гэрээ байгуулсан байна.

-Зарим тендерт оролцогч нь өмнөх ажлаа улсын комиссод актаар хүлээлгэж өгөөгүй, комисс хүлээж авах эсэх нь тодорхойгүй, тендерт оролцогчийн чадварыг одоо хийж байгаа ажилтай нь хамт үнэлээгүй, зөвхөн тухайн зарлагдсан ажлын хүрээнд үнэлж, өмнөх ажлын гэрээний хугацаа дуусаагүй байхад гэрээ байгуулах эрх олгосон байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 14.7-д “Захиалагч шаардсан тохиолдолд тендерт оролцогч хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллийг ирүүлнэ”, 14.8-д “Захиалагч энэ зүйлийн 14.7-д заасан мэдээллийг тендерт оролцогчийн тухайн гэрээг гүйцэтгэх санхүүгийн болон техникийн чадавхийг үнэлэхэд харгалзан үзнэ”, ТББ-ийн 5.2.Д-д “... одоо хийж байгаа болон хийхээр төлөвлөсөн ажлын тухай дэлгэрэнгүй мэдээлэл, ...”-ийг авна гэсэн заалт зөрчигджээ. Жишээлбэл: Дөрвөнлхагва ХХК 290.9 сая төгрөгийн 5, Өгөөмөр уул ХХК 804.5 сая төгрөгийн 5, Төв Чандмань ДЭХГ 240.4 сая төгрөгийн 4, Төв АЗЗА ХК 181.6 сая төгрөгийн 6 ажилд гэрээ байгуулах эрх олгож, гэрээ байгуулсан байна.



Төрийн үйлчилгээний нэгдсэн төв /Өгөөмөр уул ХХК-225.0 сая төгрөг,
Дэлгэр констракшн ХХК -110.9 сая төгрөг/



Цэнгэлдэх хүрээлэнгийн гол орц, гарцын явган зам засвар /Дөрвөнлхагва ХХК-79.9 сая төгрөг/



Цэвэрлэх төв байгууламжийн гадна халаалтын бүсийг сэргээн засварлах ажил /Төв Чандмань ДЭХГ-39.3 сая төгрөг/

Б.2 2017 онд улс, орон нутгийн төсвөөс хэрэгжсэн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр арга хэмжээний 42 хувь нь гэрээний хугацаанд хэрэгжээгүй, хугацаа хоцорч хэрэгжсэн буюу ашиглалтад орох хугацаандаа ороогүй байна.

2017 онд улс, орон нутгийн төсвөөс нийт 4211.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалтын 58 ажилд гэрээ байгуулагдахаас 4197.6 сая төгрөгийн өртөгтэй 55 ажилд 3719.2 сая төгрөгийн 60 ажил гүйцэтгэх гэрээ байгуулагджээ. Орон нутгийн төсвийн 46.8 сая төгрөгийн 3 ажилд гэрээ байгуулагдаагүй бөгөөд замын сангаас батлагдсан 16.8 сая төгрөгийн санхүүжилттэй 2 ажил, БОХНСАЗ-аас батлагдсан 30.0 сая төгрөгийн 1 ажилд гэрээ байгуулагдаагүй байна. Үүнээс 34.0 сая төгрөгийн 2 ажил сумдад эрх шилжсэн, 12.8 сая төгрөгийн 1 ажил хийгдээгүй байна.

Улс, орон нутгийн төсвөөс хэрэгжсэн ажлуудад дараах ажил гүйцэтгэх гэрээ байгуулагджээ. Үүнд:

-Улсын төсвөөс хэрэгжсэн 1086.9 сая төгрөгийн өртөгтэй 9 ажилд 933.5 сая төгрөгийн 12 гэрээ байгуулагдсан бөгөөд 3 их засварын ажилд 47.8 сая төгрөгийн нэмэлт ажлын гэрээ,

-Орон нутгийн төсвөөс хэрэгжсэн 3077.9 сая төгрөгийн өртөгтэй 46 ажилд 2785.7 сая төгрөгийн 48 ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдсанаас төсвийн шилжих үлдэгдлийн 2070.1 сая төгрөгийн өртөгтэй 23 ажилд 1838.7 сая төгрөгийн 25 ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдсан байна. Үүнээс иргэдэд үйлчлэх нэгдсэн төвийн их засвар, тохижилтын ажил нь 2 багц болон хуваагдаж 2 гэрээ, аймгийн ЗДТГ-ын засварын ажилд 8.9 сая төгрөгийн 1 нэмэлт ажлын гэрээ байгуулсан байна.

	Санхүүжилтийн эх үүсвэр	Батлагдсан			Гэрээ байгуулсан			
		Ажлын тоо	Төсөвт өртөг	санхүүжилт	Ажлын тоо	Гэрээний тоо	Төсөвт өртөг	Гэрээний мөнгөн дүн
1	Улсын төсөв	9	1086.9	917.1	9	12	1086.9	933.5
2	Орон нутгийн төсөв бүгд	49	3124.7	2678.6	46	48	3077.9	2785.7
	Төсвийн шилжих үлдэгдэл	23	2070.1	1648.3	23	25	2070.1	1838.7
	Орон нутгийн замын сан	13	444.2	414.7	11	11	427.4	398.2
	БОХНСАЗардал	13	610.4	615.6	12	12	580.4	548.8
	БҮГД	58	4211.6	3595.7	55	60	4164.8	3719.2

Мэргэжлийн зураг төсвийн байгууллага, төсөвчний гүйцэтгэсэн зураг төсөвтэй 5 ажилд ажил гүйцэтгэх явцад 56.7 сая төгрөгийн нэмэлт ажлын гэрээ байгуулагджээ.

Аудитын явцад гүйцэтгэгчтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулахтай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

-Аймгийн ЗДТГ-ын их засварын ажлыг Төв цогт өлзийт ХХК-аар гүйцэтгүүлэхээр 49.7 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулжээ. Ажил гүйцэтгэх явцад 8.9 сая төгрөгийн нэмэлт ажлын гэрээ байгуулсан бөгөөд гэрээний үнийн дүнгийн 17.9 хувь байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 34.1.4-т “нэмэлт ажлын өртөг нь анхны гэрээний үнийн 15 хувь болон ... тендер шалгаруулалтаар худалдан авсан ажлын нэмэлт болон түүнтэй ижил төстэй ажлыг давтан хийх тохиолдолд дахин тендер шалгаруулалт явуулснаар илүү сайн санал ирэхгүй гэж үзсэн бол гэрээ шууд байгуулна” гэсэн заалт зөрчсөн байна. Мөн тус компаниар ЗДТГ-ын зарим өрөөний засварын 12.0 сая төгрөгийн ажлыг шууд гэрээ буюу нэмэлт ажлын гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн нь мөн ТБОНӨХБАҮХАТ хуулийн 34.1.4 дэхь заалт болон 8.4-т “тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, 33.1-д “Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын арга хэрэглэнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэсэн 55 гүйцэтгэгчээс 25 нь гэрээний хугацааг 14-115 хоногоор буюу 4 сар хүртэл хугацаагаар хэтрүүлсэн байна. Жишээлбэл:

-Улсын төсвөөс хэрэгжсэн 933.5 сая төгрөгийн гэрээтэй 9 ажлаас 430.6 сая төгрөгийн 4 ажил,

-Орон нутгийн төсвөөс хэрэгжсэн 2785.7 сая төгрөгийн 46 ажлаас 1479.4 сая төгрөгийн 21 ажил гэрээний хугацаа хэтрүүлжээ.

	Санхүүжилтийн эх үүсвэр	Гэрээ байгуулсан				Хугацаа хэтэрсэн	
		Ажлын тоо	Гэрээний тоо	Төсөвт өртөг	Гэрээний мөнгөн дүн	Хугацаа хэтэрсэн ажлын тоо	Гэрээний мөнгөн дүн
1	Улсын төсөв	9	12	1086.9	933.5	4	430.6
2	Орон нутгийн төсөв бүгд	46	48	3077.9	2785.7	21	1479.4
	Төсвийн шилжих үлдэгдэл	23	25	2070.1	1838.7	14	1247.1
	Орон нутгийн замын сан	11	11	427.4	398.2	4	113.6
	БОХНСАЗардал	12	12	580.4	548.8	3	118.7
	БҮГД	55	60	4164.8	3719.2	25	1910.0

Судалгаанаас харахад хугацаа хэтэрсэн 25 ажлын гүйцэтгэгч нь 19 компани байна. Зарим гүйцэтгэгч нь ОНХС болон улс, орон нутгийн төсвийн 2-6 ажлыг гэрээгээр гүйцэтгэж, гүйцэтгэсэн ажлууд нь гэрээний хугацаа хэтэрчээ. Жишээлбэл:

-Өгөөмөр уул ХХК 2017 онд 804.5 сая төгрөгийн 5 ажил гүйцэтгэж, актаар хүлээлгэж өгөхөөс 2016 онд ашиглалтад орох байсан боловч он дамжин хэрэгжсэн 275.0 сая төгрөгийн 1 ажил 63 хоногоор, үлдсэн 529.5 сая төгрөгийн 4 ажилд гэрээ байгуулснаас 430.6 сая төгрөгийн 3 ажил 22-56 хоног,

-Баткомплект ХХК 192.6 сая төгрөгийн 2 ажил гэрээгээр гүйцэтгэж, 10-52 хоног,

-Дөрвөнлхагва ХХК 290.9 сая төгрөгийн 5 ажил гэрээгээр гүйцэтгэж, 210.9 сая төгрөгийн 4 ажил 14-36 хоног,

-Төв Чандмань ДЭХГ 240.4 сая төгрөгийн 4 ажил гэрээгээр гүйцэтгэж, 169.8 сая төгрөгийн 2 ажил 20 хоног,

-Төв АЗЗА ХК 181.6 сая төгрөгийн 6 ажил гэрээгээр гүйцэтгэж 69.7 сая төгрөгийн 2 ажил 20-90 хоногоор хоцорч улсын комиссын актаар хүлээж авсан байна.

Гэрээний хугацаа хэтэрсэн шалтгааныг судалж үзэхэд зарим гүйцэтгэгчтэй ажил нь дуусаагүй, актаар хүлээлгэж өгөөгүй байхад дараагийн ажилд гэрээ байгуулах эрх олгосноос гэрээний хугацаа хэтэрдэг байна. Мөн гүйцэтгэгчээс өөрөөс нь шалтгаалахаас гадна цаг агаар, захиалагчаас шалтгаалсан байна. Зураг, төсөвгүй ажилд санхүүжилт баталснаас ХАА явагдахын өмнө богино хугацаанд зураг, төсөв хийлгэснээс зураг төсөвт тусгасан ажлын тоо хэмжээ зөрөх, дутах, ажил гүйцэтгэх хугацааг дутуу тооцсоноос гүйцэтгэгч гэрээний хугацаанд ажил гүйцэтгэх боломжгүй болох, мөн гүйцэтгэгчээс ажил хүлээлцэх комисс ажиллуулах тухай албан тоот хүргүүлсэн боловч комисс хугацаа алдаж хүлээн авсан зэргээс шалтгаалжээ.

Зарим онцлог хөрөнгө оруулалтын ажил буюу ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн ажлыг хийсний дараа тухайн ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх аж ахуйн нэгж байгууллагыг шийдвэрлээгүйгээс тухайн гүйцэтгэгч компани нь гэрээний хугацаанд ажлаа улсын комисст хүлээлгэж өгсөн, гүйцэтгэлийн баталгааны хугацаа нь дуусаагүй байхад хийсэн хөрөнгө оруулалтын ажлын үр дүн байхгүй болсон байна. Жишээлбэл: Тахил төгөл ХХК-ий гүйцэтгэсэн 44.8 сая төгрөгийн соёл амралтын хүрээлэнгийн зүлэгжүүлэлтийн ажлаар таригдсан 19090 ширхэг мод тоо хэмжээндээ хүрэхгүй, гэрээт ажлаа бүрэн гүйцэтгэсэн эсэх нь тодорхойгүй, ажлын

гүйцэтгэлийг тооцох боломжгүй болсон бөгөөд мод, суулгацын 90-ээс дээш хувь нь ургаагүй, тарьсан зүлэг нь байхгүй болсон, жишиг ногоон байгууламж байгуулах ажлаар Ногоон хөгжлийн зам ХХК 20.0 сая төгрөгөөр тарьсан 6000 ширхэг модны дийлэнх нь ургаагүй зэргээс харахад зарим хөрөнгө оруулалтын ажлын үр дүн байхгүй болсон байна.



Соёл амралтын хүрээлэнгийн зүлэгжүүлэлт /Тахил төгөл ХХК-44.8 сая төгрөг/



Жишиг ногоон байгууламж /Ногоон хөгжлийн зам ХХК-20.0 сая төгрөг/

Б.3 Захиалагчаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчтэй тооцох хариуцлагыг бүрэн тооцоогүй, зарим гэрээний хугацаа хэтэрсэн хоногт тооцох алдангийн хэмжээ тодорхойгүй, чанарын баталгаат хугацааны барьцаа хөрөнгийг бүрэн тооцож аваагүй байна.

Захиалагч нь “Барилгын тухай” хуулийн 14.8-д “Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга байгууламжид энэ хуулийн 14.3-т заасан хугацаанд гүйцэтгэгчээс хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн тодорхой хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43.6-д заасны дагуу зохицуулна”, ТБОНӨХБАУХАТ хуулийн 43.6-д “Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг захиалагч тендерийн баримт бичигт тусгаж болно”, 2016 оны Сангийн сайдын “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.19-д “Барилгын чанарын баталгаат хугацаа “Барилгын тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийг баримтлах бөгөөд баталгаат хугацаанд байгалийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс бусад шалтгаанаас үүдэн барилга, байгууламжид эвдрэл, гэмтэл гарвал гүйцэтгэгч байгууллага захиалагчийн шаардлагаар үнэ төлбөргүй засварлана” гэсэн заалтын дагуу улсын төсвийн хөрөнгөөр гэрээгээр ажил гүйцэтгэсэн 3 компаниас 10.9 сая төгрөгийн, орон нутгийн төсвийн хөрөнгөөр гэрээгээр ажил гүйцэтгэсэн 3 компаниас 11.6 сая төгрөгийн, нийт 6 ажлын 22.5 сая төгрөгийг барилгын ажлын чанарын баталгааны барьцаанд авчээ.

Мөн 77.9 сая төгрөгийн гэрээтэй соёл амралтын хүрээлэнд усан оргилуур байгуулах ажлын гүйцэтгэгч Тонгил ХХК-аас дутуу ажлын санхүүжилт 6.2 сая төгрөгийг суутган тооцжээ.



Соёл, амралтын хүрээлэнгийн усан оргилуур /Тонгил ХХК-77.9 сая төгрөг/

Улс, орон нутгийн төсвөөс хэрэгжсэн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр арга хэмжээний 42 хувь нь гэрээний хугацаанд хэрэгжээгүй нь захиалагчаас тавих хяналт

хангалтгүй, хугацаа хэтэрсэн хоногт алданги тооцохоос өөр хариуцлага байхгүй, хугацаа хэтэрсэн ч алданги тооцогддоггүй зэрэг шалтгаанаар гэрээгээр ажил гүйцэтгэсэн компаниуд гэрээний үүргээ биелүүлээгүй байна. Захиалагчаас улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй 2 гүйцэтгэгчид 1.2 сая төгрөгийн алданги тооцсон, бусад 23 гүйцэтгэгчтэй хариуцлага тооцоогүй байна. Мөн ТББ-ийн гэрээний тусгай нөхцөлийн ГЕН-ийн 13.1-д “Хугацаа хэтэрсэн нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн /хувь/ байна” гэсэн боловч зарим ажлын алдангийн хувийг тодорхой зааж өгөөгүй байна.

Б.4 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 5 ажилд 73.6 сая төгрөгийн нэмэлт ажлын гэрээ байгуулсан боловч 8.8 сая төгрөгийн магадалшгүй ажлын зардлыг актаар санхүүжүүлжээ.

2017 онд хөрөнгө оруулалтад нийт 61 ажилд 3642.5 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 55 ажилд гүйцэтгэгчтэй 3719.2 сая төгрөгийн 60 гэрээ байгуулагдаж, гэрээт ажлын 3572.0 сая төгрөгийн, сумдад эрх шилжиж хэрэгжсэн 34.0 сая төгрөгийн, нийт 3606.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Эдгээр ажлын үлдэгдэл санхүүжилт 160.0 сая төгрөг бөгөөд замын сангаас хэрэгжих 12.8 сая төгрөгийн 1 ажил хэрэгжээгүй, үлдсэн 147.2 сая төгрөг нь 2017 онд хэрэгжсэн гэрээт ажлын үлдэгдэл санхүүжилт байна. Үүнд:

-Улсын төсөв буюу Эрчим хүчний сайдын багцаас хэрэгжсэн Батсүмбэр сумын Сөгнөгөр багийн цахилгаан хангамжийн шинэчлэл АТП-8190 -ийн 0.4-н агаарын шугамын угсралтын ажлын үлдэгдэл санхүүжилт 63.4 сая төгрөг,

-Орон нутгийн төсвийн 5 ажлын 83.8 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилт байна. Үүнээс БОХНАЗ-аас он дамжин хэрэгжсэн 2 ажлын үлдэгдэл санхүүжилт 40.6 сая төгрөг, үлдсэн 43.2 сая төгрөг нь тухайн онд хэрэгжсэн 3 гэрээт ажлын үлдэгдэл санхүүжилт байна.

	Санхүүжилтийн эх үүсвэр	Батлагдсан		Гэрээ байгуулсан				санхүүжилт	
		Ажлын тоо	санхүүжилт	Ажлын тоо	Гэрээний тоо	Төсөвт өртөг	Гэрээний мөнгөн дүн	Бүгд	Үлдэгдэл
1	Улсын төсөв	9	917.1	9	12	1086.9	933.5	870.1	63.4
2	Орон нутгийн төсөв бүгд	52	2725.4	46	48	3077.9	2785.7	2735.9	96.6
	Төсвийн шилжих үлдэгдэл	23	1648.3	23	25	2070.1	1838.7	1799.5	39.2
	Орон нутгийн замын сан	13	414.7	11	11	427.4	398.2	398.2	0
	Сумд	2	16.8					4.0	12.8
	БОХНАЗЗардал	13	615.6	12	12	580.4	548.8	504.2	44.6
	Сумд	1	30.0					30.0	0
	БҮГД	61	3642.5	55	60	4164.8	3719.2	3606.0	160.0

Аудитын явцад санхүүжилттэй холбоотой дараах зөрчил гарлаа. Үүнд:

-Улсын төсвөөс хэрэгжсэн 3 их засварын ажилд 47.8 сая төгрөгийн нэмэлт ажлын гэрээ байгуулж 5.9 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс хэрэгжсэн 1 ажилд 8.9 сая төгрөгийн нэмэлт ажлын гэрээ байгуулж 0.9 сая төгрөгийн, нийт 4 ажилд нэмэлт ажлын гэрээ байгуулсан боловч 6.8 сая төгрөгийн магадалшгүй ажлын зардлыг актаар санхүүжүүлжээ. Мөн улсын төсвөөс хэрэгжсэн Зууны сод хийц ХХК-ий гүйцэтгэсэн 118.0 сая төгрөгийн гэрээтэй Эрдэнэсант сумын Залуучуудын соёл, спортын төвийн барилгын засварын ажилд сумын ОНХС-аас 16.9 сая төгрөгийн нэмэлт ажлын гэрээ байгуулсан боловч улсын төсвөөс санхүүжсэн 118.0 сая төгрөгийн гэрээт ажлын магадалшгүй ажлын зардал 2.0 сая төгрөгийг актаар санхүүжүүлжээ. Энэ нь ТББ-нд "... Магадалшгүй ажлын зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

-Төв Чандмань ДЭХГ-ын гүйцэтгэсэн 130.5 сая төгрөгийн санхүүжилттэй Баруун Зуунмод багийн гэр хорооллын гадна дулаан хангамж, цэвэр бохир усны шугам угсралтын ажлын зураг, төсвийн үнэ 0.8 сая төгрөгийг суутган тооцоогүй,

-БОХНСАЗ-аас хэрэгжсэн цөлжилтөөс урьдчилан сэргийлэх ажлыг 58.6 сая төгрөгөөр гүйцэтгэх гэрээ байгуулсан Хүрэн баавгай ХХК-аас захиалагчийн суутган тооцох хяналтын зардал, магадалшгүй ажлын зардлын зөрүү нийт 1.9 сая төгрөгийг /1853260/ суутган тооцоогүй байна. Эдгээр зөрчил нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-ын 4.18-д "Захиалагч барилгын ажлын зардал, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсвийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, нормчлолын сангийн зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг тус тусын дансанд холбогдох баримт, материалыг үндэслэн шилжүүлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Санхүүжилт нь батлагдсан зураг, төсвийн дагуу хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлын 75 хувь нь шаардлага хангаагүй байна.

2. Зураг, төсөвгүй ажилд санхүүжилт батлагдсанаас худалдан авах ажиллагаа ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу явагдаагүй байна.

3. Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээний 42 хувь нь гэрээний хугацаанд хэрэгжээгүй, ашиглалтад орох хугацаандаа ороогүй байна.

4. Захиалагчаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчтэй тооцох хариуцлагыг бүрэн тооцоогүй, зарим гэрээний хугацаа хэтэрсэн хоногт тооцох алдангийн хэмжээ тодорхойгүй, чанарын баталгаат хугацааны барьцаа хөрөнгийг бүрэн тооцож аваагүй байна.

5. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 5 ажилд 73.6 сая төгрөгийн нэмэлт ажлын гэрээ байгуулсан боловч 8.8 сая төгрөгийн магадалшгүй ажлын зардлыг актаар санхүүжүүлжээ.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн аймгийн Засаг дарга Ж.Батжаргал, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Д.Саран-Эрдэнэ, Орон нутгийн өмчийн газрын дарга Д.Батжаргал, ГХБХБГ-ын дарга М.Отгонбат нарт зөвлөх нь:

1.Хөрөнгө оруулалтын ажлын зураг, төсөв, газрын зөвшөөрөл гэх мэт бусад шаардлага хангасан, батлагдсан төсөвтэй төсөл, арга хэмжээнд санхүүжилт батлах.

2.Худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу батлагдсан төсөвт өртгийг үндэслэн явуулах, тендерт оролцогчдын хэрэгжүүлэх эрх авсан гэрээг оролцогчийн чадварыг үнэлэхэд харгалзан үзэж, давхар гэрээ байгуулах эрх олгохоос зайлсхийх.

3.Төсвийн хөрөнгөөр ажил гүйцэтгэх гэрээний дагуу ажил гүйцэтгэгч нарын гэрээний хугацаа болон ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах.

4.Захиалагчаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчтэй тооцох хариуцлагыг бүрэн тооцож, гэрээ болон ТББ-т хугацаа хэтэрсэн хоногт тооцох алдангийн хэмжээг тодорхой болгож, чанарын баталгаат хугацааны барьцаа хөрөнгийг бүрэн тооцож авах.

5.Батлагдсан зураг төсвийн дагуу ажлыг гүйцэтгүүлж, тендерт шалгарсан өртгөөр ажлыг гүйцэтгүүлэх, нэмэлт ажлын гэрээ, нэмэлт гэрээ байгуулсан тохиолдолд магадалшгүй ажлын зардлыг актаар санхүүжүүлэхийг зогсоох.

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал



**ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР**

41100, Зуунмод, Төв аймаг
Утас: 70273623, Факс: 70272237

2018.06.21 № 04/1260
танай _____-ны № _____-т

**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Санал хүргүүлэх тухай

“Улс, орон нутгийн төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцаад холбогдох саналаа хүргүүлж байна. Үүнд:

-Аймгийн ЗДТГ, ГХБХБГ, ОНӨГ-аас тухайн оны хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөг батлуулахдаа зураг төсөвтэй байлгахад анхааран ажиллаж хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлагдахаас өмнө зураг төсвийг гүйцэтгүүлэн ажиллаж байгаа.

Төсвийн тодотголоор батлагдаж хийсэн ажлуудын төсвийг 2017 онд боловсруулсан бөгөөд аймаг, орон нутагт зайлшгүй хийх шаардлагатай зарим ажлуудын хийхээр тусгасан бөгөөд энэхүү ажлуудыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж батлуулахдаа зураг төсөвтэй батлуулсан болно.

Мөн дүгнэлтэд 2017 онд зураг төсөв хийсэн ажлуудын жагсаалтад зам засвар, арчлалтын ажлууд орсон байна. Зам арчлалт, засварын ажлуудыг орсон цасны хэмжээ, давтамжаас шалтгаалж гүйцэтгэлээр нь хянаж баталгаажуулдаг тул зураг төсөв хийх шаардлагагүй ажлууд байдаг болно.

- Баянцагаан сумын ЭМТ-н барилгын ажил 109.6 сая төгрөгийн төсөвтэй. Улсын хөрөнгө оруулалтаар 80.0 сая төгрөг батлагдаж, төрийн худалдан авах ажиллагааны цахим www.tender.gov.mn системд эрх шилжиж ирсэн. Үүнд нь багтааж тендер зарласан.

- 5 сумын ЗДТГ-ын автомашин шинэчлэх- 159.6 сая төгрөг батлагдсан. Нэр бүхий сумдад төсвийн хөрөнгө оруулалтаар шинэ машин авах хөрөнгө хүрэлцэхгүй, нэгдсэн тендер зарлаж, бөөнөөр машин авах боломжгүй, нэгэнт шинэ автомашин авах боломжгүй тул сум бүр өөрийн онцлогтоо тохируулан авах автомашины санал нь харилцан адилгүй байсан тул 2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд сум тус бүрийн автомашины тендер шалгаруулалтыг тусад нь төлөвлөж, төрийн худалдан авах ажиллагааны цахим www.tender.gov.mn системд бүртгэн оруулж, төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулсан. Төлөвлөгөөнд тусгасны дагуу харьцуулалтын аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулсан.

020795

- Батсүмбэр сумын Сөгнөгөр багийн цахилгаан хангамжийн шинэчлэл АПТ-8190-ийн 0.4-н шугамын, 200.0 сая төгрөгийн ажлын тендер шалгаруулалт нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалтын дагуу зохион байгуулагдсан бөгөөд байгалийн давагдашгүй, онцгой нөхцөл байдал үүссэн нь нотлогдсон тул гэрээ шууд байгуулах зөвлөмжийг хүргүүлсэн.

- 2017 онд зохион байгуулагдсан тендер шалгаруулалтын үнэлгээний хорооны 3-4 гишүүнд ОНӨГазрын худалдан авах ажиллагааны болон бусад мэргэжилтнүүд орж ажилласан. ТБОНӨХБАҮХАТХууль, Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журамд зааснаар үнэлгээний хороонд АЗ гэрчилгээ буюу худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн иргэн, албан тушаалтан орно гэж заасан. Аймгийн хэмжээнд АЗ гэрчилгээтэй албан хаагч, иргэдийн нөөц хомс, дутагдалтай байсан бөгөөд үнэлгээний хороонд орж ажиллах сонирхолгүй, хариуцлага өндөр, шалгалтанд тэнцдэггүй зэрэг шалтгаанаар албан хаагч, иргэний төлөөлөл бүрдэхгүй байсан тул тухайн байгууллагын АЗ гэрчилгээтэй үндсэн ажилтнууд ажиллаж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан. 2017 онд АЗ гэрчилгээний сургалтыг 2 удаа зохион байгуулан, иргэдийн төлөөлөл болон албан тушаалтны тоог нэмэгдүүлсэн.

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх Цээл, Баянцагаан сумын ЭМТ-ийн, Эрдэнэсант сумын соёл, спортын төвийн барилга засварын нэр бүхий 6 ажлын төсөвт өртгийг бууруулсан гэсэн дүгнэлт гарсан байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжиж ирсэн эдгээр ажлууд нь холбогдох яамдад төсөвлөгдөж, батлагдсан ажлууд бөгөөд төрийн худалдан авах ажиллагааны цахим www.tender.gov.mn системээр “бууруулсан” гэх төсөвт өртгөөр батлагдаж, нээлттэй тендер шалгаруулалт болон харьцуулалтын аргаар зарлагдахаар төлөвлөгдөж, эрх шилжиж ирсэн. Батлагдсан төсөвт өртгийг нь үндэслэн тендер зарласан.

- Давхар ажил гүйцэтгэж байгаа тендер оролцогчийн чадварыг үнэлээгүй гэж дүгнэсэн тухайд ТБОНӨХБАҮХАТХуульд давхар ажил гүйцэтгэж байгаа тендер оролцогчийг шалгаруулахыг хязгаарласан заалт тусгагдаагүй тул үүнийг үнэлгээнд харгалзаагүй.

- ЗДТГазрын зарим өрөөний засварын 12.0 сая төгрөгийн ажлын тухайд ажил гүйцэтгэх явцад шалан доороос ашиглалтын шаардлага хангахгүй шугам хоолой гарч шалыг бүтэн хуулж шугамыг шинэчлэн солих зайлшгүй шаардлага гарсан. Нэгэнт тендер шалгарсан компанийн гүйцэтгэж байгаа ажлыг зогсоон дахин тендер явуулах боломжгүй байсан тул нэмэлт ажлын гэрээгээр хийгдэх зайлшгүй ажлуудыг хийж гүйцэтгүүлсэн

болно. Мөн тухайн үед ЗДТГ-т засварын ажил гүйцэтгэж байгаа компаниар шууд зардлаар нь ЗДТГ-ын өрөөг засварлуулсан болно.

-Мөн Магадлашгүй ажлын хөрөнгөөр хийж гүйцэтгээд ч нэмэлтээр хийх ажил байгаа тохиолдолд Нэмэлт ажлын гэрээ байгуулан ажиллаж байгаа болно

Зураг, төсөвгүй ажилд санхүүжилт батлагдсанаас худалдан авах ажиллагаа ТБОНӨХБАҮХАТХуулийн дагуу явагдаагүй тухай дүгнэлт гарсан байна. Уг дүгнэлтээр тендер шалгаруулалт хуулийн дагуу явагдаагүй гэж ойлгогдохоор байгаа тул анхаарч үзэхийг хүсье.

Аудитын зөвлөмжтэй танилцлаа.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.САРАН-ЭРДЭНЭ





**ТӨВ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272262., Факс: 70272192

2018.05.18 № 07/463
танай 2018.06.15-ны № 1/339 -т

**ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хийгдсэн ажлуудад гүйцэтгэлийн аудит хийсэн ажлын тайланг дараах засвар хийгдэх байдлаар хүлээн зөвшөөрч байна.

Үүнд:

- Аудит хийх явцад хугацааны алдангийн талаар захиалагч инженер, гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн өгсөн тайлбарыг дүгнэлтэд засварлан тусгах,
- 2017 оны улс, орон нутгийн хөрөнгө оруулалтын ажлуудын жагсаалтыг батлахдаа 25 хувь нь батлагдсан зураг төсөлтэй, 75 хувь нь зураг төсөв нь батлагдаагүй байна" гэж тодорхой ойлгомжтой болгон засварлах,
- "Нийт хөрөнгө оруулалтын ажлын 42 хувь нь гэрээний хугацаа хэтэрсэн" гэжээ. Үүний шалтгаан нь санхүүжилт, цаг агаарын байдал, ашиглалтад хүлээн авах комисс удаашралтай ажилласан зэрэг шалтгаануудыг харгалзан үзэж дүгнэлтэд тусгаж өгөхийг хүсье.

ДАРГА



М.ОТГОНБАТ

20180303

My doc toot A-5



**ТӨВ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70273539, Факс: 70273579

**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

2018.06.21 № 211
танай 2018.06.15 -ны № 1/338 -т

Танай газраас “Улс, орон нутгийн төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланд холбогдох саналаа ирүүлэхийг хүссэн байна.

Аудитын дүгнэлтэд тусгагдсан дараах ажлуудад тайлбар хүргүүлж бана.

Үүнд:

- Баянцагаан сумын ЭМТ-н барилгын ажил 109.6 сая төгрөгийн төсөвтэй. Гэтэл улсаас 80.0 сая төгрөг батлагдаж, төрийн худалдан авах ажиллагааны цахим www.tender.gov.mn системд эрх шилжиж ирсэн. Үүнд нь багтааж тендер зарласан.

- 5 сумын ЗДТГ-ын автомашин шинэчлэх- 159.6 сая төгрөг батлагдсан. Нэр бүхий сумдад төсвийн хөрөнгө оруулалтаар шинэ машин авах хөрөнгө хүрэлцэхгүй, нэгдсэн тендер зарлаж, бөөнөөр машин авах боломжгүй гэж үзэн, 2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд сум тус бүрийн автомашины тендер шалгаруулалтыг зохион байгуулах зорилгоор тусад нь төлөвлөж, төрийн худалдан авах ажиллагааны цахим www.tender.gov.mn системд бүртгэн оруулж, төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулсан. Төлөвлөгөөнд тусгасны дагуу харьцуулалтын аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулсан.

- Батсүмбэр сумын Сөгнөгөр багийн цахилгаан хангамжийн шинэчлэл АПТ-8190-ийн 0.4-н шугамын, 200.0 сая төгрөгийн ажлын тендер шалгаруулалт нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалтын дагуу зохион байгуулагдсан бөгөөд байгалийн давагдашгүй, онцгой нөхцөл байдал үүссэн нь нотлогдсон тул гэрээ шууд байгуулах зөвлөмжийг хүргүүлсэн.

- Аймгийн ЗДТГазарт 180.0 сая төгрөгийн автомашин шинэчлэх ажил нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, АЗДТГазраас зохион байгуулагдсан тул энэхүү тайлангаас хасуулах саналтай байна.

- 2017 онд зохион байгуулагдсан тендер шалгаруулалтын үнэлгээний хорооны 3-4 гишүүнд ОНӨГазрын худалдан авах ажиллагааны болон бусад

201804110

мэргэжилтнүүд орж ажилласан. ТБОНӨХБАҮХАТХууль, Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журамд зааснаар үнэлгээний хороонд АЗ гэрчилгээ буюу худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн иргэн, албан тушаалтан орно гэж заасан. Аймгийн хэмжээнд АЗ гэрчилгээтэй албан хаагч, иргэдийн нөөц хомс, дутагдалтай байсан бөгөөд үнэлгээний хороонд орж ажиллах сонирхолгүй, хариуцлага өндөр, шалгалтанд тэнцдэггүй зэрэг шалтгаанаар албан хаагч, иргэний төлөөлөл бүрдэхгүй байсан тул тухайн байгууллагын АЗ гэрчилгээтэй үндсэн ажилтнууд ажиллаж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан. 2017 онд АЗ гэрчилгээний сургалтыг 2 удаа зохион байгуулан, иргэдийн төлөөлөл болон албан тушаалтны тоог нэмэгдүүлсэн.

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх Цээл, Баянцагаан сумын ЭМТ-ийн, Эрдэнэсант сумын соёл, спортын төвийн барилга засварын нэр бүхий 6 ажлын төсөвт өртгийг бууруулсан гэсэн дүгнэлт гарсан байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжиж ирсэн эдгээр ажлууд нь холбогдох яамдад төсөвлөгдөж, батлагдсан ажлууд бөгөөд төрийн худалдан авах ажиллагааны цахим www.tender.gov.mn системээр “бууруулсан” гэх төсөвт өртгөөр батлагдаж, нээлттэй тендер шалгаруулалт болон харьцуулалтын аргаар зарлагдахаар төлөвлөгдөж, эрх шилжиж ирсэн. Батлагдсан төсөвт өртгийг нь үндэслэн тендер зарласан.

- Давхар ажил гүйцэтгэж байгаа тендерт оролцогчийн чадварыг үнэлээгүй гэж дүгнэсэн тухайд ТБОНӨХБАҮХАТХуульд давхар ажил гүйцэтгэж байгаа тендерт оролцогчийг шалгаруулахыг хязгаарласан заалт тусгагдаагүй тул үүнийг үнэлгээнд харгалзаагүй.

- ЗДТГазрын зарим өрөөний засварын 12.0 сая төгрөгийн ажил нь тус газраас зарлагдаагүй, зохион байгуулагдаагүй тул энэхүү тайлангаас хасуулах саналтай байна.

- Нэмэлт гэрээ байгуулсан ажлыг захиалагч байгууллага болох ГХБХБГазраас тодруулах нь зүйтэй.

- “Тахил төгөл” ХХК-ний 44.8 сая, “Ногоон хөгжлийн зам” ХХК-ний 20.0 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авалтыг захиалагч байгууллагуудаас ирүүлсэн ажлын тоо, хэмжээний дагуу зарлаж, тендер шалгаруулалтын үр дүнг захиалагчдад хүргүүлэн ажилласан.

- Зураг, төсөвгүй ажилд санхүүжилт батлагдсанаас худалдан авах ажиллагаа ТБОНӨХБАҮХАТХуулийн дагуу явагдаагүй дүгнэлт гарсан байна. Уг

дүгнэлтээр тендер шалгаруулалт хуулийн дагуу явагдаагүй гэж ойлгогдохоор байна.

Орон нутгийн өмчийн газар нь улс, аймаг орон нутгийн төсвийн эх үүсвэрээр батлагдсан төсөв, санхүүжилтийн дүнг үндэслэн, захиалагч байгууллагаас ирүүлсэн зураг, төсвийн ажлын тоо хэмжээний дагуу худалдан авах ажиллагааны холбогдох журмын дагуу тендер шалгаруулалтыг зохион байгуулж ажилласан.

2017 оноос эхлэн төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ашиглалтад орж, тус газар нь 2017 онд хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-аас баталсан санхүүжилт, түүний тогтоол, шийдвэр мөн ТЕЗ-н тухайн оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн, төрийн худалдан авах ажиллагааны цахим tender.gov.mn системд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг нэгтгэн оруулсны үндсэн дээр Сангийн яаманд хянуулж, батлуулснаар захиалагч байгууллагаас ирүүлсэн зураг, төсөв, техник эдийн засгийн үндэслэл, ажлын даалгаврыг үндэслэн цахим системээр уламжлалт болон цахим тендер шалгаруулалтыг зохион байгуулж ажилласан. Тус газар нь хөрөнгө оруулалтын зураг, төсөв, техник эдийн засгийн үндэслэл, ажлын даалгавар боловсруулах, батлуулах эрх бүхий байгууллага биш бөгөөд цаашид хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажлын зураг, төсөв, техник эдийн засгийн үндэслэл, ажлын даалгавар зэргийг төсөв батлуулахад холбогдох мэргэжлийн байгууллага нь бэлэн болгож, аймгийн ИТХ-аар батлуулж байх нь зүйтэй байна.

Иймд зураг, төсөвгүй ажилд санхүүжилт нь батласан талаарх дүгнэлтийг худалдан авах ажиллагаанаас тусад нь дүгнэж өгнө үү.

Аудитын зөвлөмжтэй танилцлаа.

ДАРГА



Д. БАТЖАРГАЛ

Холбогдох байгууллагын саналын дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ

Тус тайлантай холбогдох саналыг аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, аймгийн Орон нутгийн өмчийн газар, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн байна. Эдгээр газруудаас ирүүлсэн саналын дагуу дараах арга хэмжээг авч, тайлбарыг гаргаж байна. Үүнд:

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсээс ирүүлсэн саналын дагуу:

Санал 1: Тайлангийн А.2-т зөрчигдсөн хуулийн холбогдох заалтыг орууллаа.

Санал 2: Тайлангийн А.2-т *“Жагсаалтаар батлагдсан төсөл арга хэмжээнээс зураг, төсвийн дагуу хийгдэх 3311.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 40 хөрөнгө оруулалтын ажлаас 1229.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ажлын зураг, төсөв 2016 онд хийгдэж, үлдсэн 2081.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 30 ажлын зураг, төсөв 2017 онд хийгдсэн байна. Үүнд:*

-Орон нутгийн замын сангийн 409.2 сая төгрөгийн өртөгтэй 12 ажлаас 140.8 сая төгрөгийн өртөгтэй 7 ажлын” гэсэн өгүүлбэрээс саналын дагуу зам арчлалтын *61.8 сая төгрөгийн 3 ажлыг зураг, төсөвтэй ажлын жагсаалтаас хасаж орууллаа.*

Санал 3: Зөрчигдсэн холбогдох хуулийн заалтыг тайланд тусгасан тул тайлбар хийх, өөрчлөх шаардлагагүй.

Санал 4,5: тайланд тусгасан өгүүлбэр нь ХАА явагдсан шалтгааныг тайлбарласан тайлбар өгүүлбэр тул тайлбар хийх, өөрчлөх шаардлагагүй.

Санал 6: Үнэлгээний хорооны бүрэлдэхүүний талаар тайлбар ирүүлсэн гэж үзсэн тул тайланд тайлбар хийх, өөрчлөх шаардлагагүй.

Санал 7: Аймгийн Засаг даргад эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын ажлуудын төсөвт өртгийг мэргэжлийн байгууллагын төсөвт өртгөөр бус батлагдсан санхүүжилтээр тооцсон байгаа тул тайланд тайлбар хийх, өөрчлөх шаардлагагүй.

Санал 8: Тайланд давхар ажил гүйцэтгэж байгаа тендерт оролцогчийн эрхийг хязгаарлах талаар дурдаагүй бөгөөд үнэлгээнд оруулж үнэлээгүй талаар дурдсан тул тайланд тайлбар хийх, өөрчлөх шаардлагагүй. Учир нь давхар ажил гүйцэтгэсэн гүйцэтгэгч нар нь гэрээний хугацаа хэтрүүлсэн байна.

Санал 9: Аймгийн ИТХ-ын “Төсвийн тодотгол”-д хийсэн тогтоолд уг ажлыг “зарим өрөөний засварын ажил” гэж 12.0 сая төгрөг баталсан байх тул ТБОНӨХБАҮХАТ хуулиар харьцуулалтын аргаар тендер явуулах тул тайланд тайлбар хийх, өөрчлөх шаардлагагүй.

Санал 10: ТББ-нд “... Магадалшгүй ажлын зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байх тул цаашид нэмэлт ажлын гэрээ байгуулах давхар магадалшгүй ажлыг санхүүжүүлэхгүй байхад анхаарч ажиллахыг зөвлөмжөөр хүргүүлсэн тул тайланд тайлбар хийх, өөрчлөх шаардлагагүй.

Санал 11: Зураг, төсөвгүй ажилд санхүүжилт батлагдсанаас худалдан авах ажиллагаа ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу явагдаагүй гэсэн дүгнэлт нь тендер шалгаруулалт хуулийн дагуу явагдаагүй гэж ойлгогдохоор байгаа тул анхаарч үзнэ үү гэсэн саналын дагуу аудитын тайлангийн ерөнхий дүгнэлтийг төлөвлөлт болон ажлын гүйцэтгэл талаас нь өглөө.

ГХБХБГ-аас ирүүлсэн саналын дагуу:

Санал 1: Аудит хийх явцад хугацааны алдангийн талаар захиалагч болон гүйцэтгэгч нараас албан ёсны тайлбар ирүүлээгүй болно.

Санал 2: “2017 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь батлагдсан зураг, төсвийн дагуу хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлын 75 хувь нь шаардлага хангаагүй байна” гэсэн дүгнэлтийг тодорхой болгох гэсний дагуу “2017 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр жагсаалтаар батлагдсан хөрөнгө оруулалтын ажлын 28 хувь нь зураг, төсөвтэй, 72 хувь нь зураг, төсөвгүй, хөрөнгө оруулалтын ажлын шаардлага хангаагүй байна.” гэж өөрчиллөө.

Санал 3: Хавсралтаар тайланд гэрээний хугацаа хэтэрсэн гүйцэтгэгч тус бүрээр тайлбарыг гаргасан байгаа тул тайланд тайлбар хийх, өөрчлөх шаардлагагүй.

Аймгийн орон нутгийн өмчийн газраас ирүүлсэн саналын дагуу:

Санал 1: Зөрчигдсөн холбогдох хуулийн заалтыг тайланд тусгасан тул тайлбар хийх, өөрчлөх шаардлагагүй.

Санал 2, 3: Тайланд тусгасан өгүүлбэр нь ХАА явагдсан шалтгааныг тайлбарласан тайлбар өгүүлбэр тул тайлбар хийх, өөрчлөх шаардлагагүй.

Санал 4, 8, 9, 10, 12: тус гүйцэтгэлийн аудит нь аймгийн хэмжээнд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилтэд хийсэн аудит бөгөөд зөвхөн орон нутгийн өмчийн газрын зохион байгуулсан худалдан авах ажиллагааны талаар бичигдээгүй тул тайлангаас хасах боломжгүй юм.

Санал 5: Үнэлгээний хорооны бүрэлдэхүүний талаар тайлбар ирүүлсэн гэж үзсэн тул тайланд тайлбар хийх, өөрчлөх шаардлагагүй.

Санал 6, 7: ХБХ-ээс ирүүлсэн саналын 7,8-д хариулсан.

Санал: 9: ХБХ-ээс ирүүлсэн саналын 11-д хариулсан.